



**“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/147

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Цоож, пайз, тусгаарлалт, энергийн хяналтын журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. “Таван толгой түлш” ХХК-ийн нийт албан тушаалтан, гэрээт болон туслан гүйцэтгэгч байгууллага, тэдгээрийн ажилтнууд тус журмыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Тус журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг тооцож гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /П.Амарцэцэг/-д зөвшөөрсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.ГАНБААТАР




Цоож, пайз,  
тусгаарлалт, энергийн  
хяналтын журам

СҮАЖ-ЦПТЭХЖ-11


Хувилбар: 1

Тушаал №



## ЦООЖ, ПАЙЗ, ТУСГААРЛАЛТ, ЭНЕРГИЙН ХЯНАЛТЫН ЖУРАМ

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:		Д.Батбаатар	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:		Э.Амарсайхан- М.Баярцэнгэл	ХАБЭА-н бүртгэл хяналтын ажилтан	

	Цоож, пайз, тусгаарлалт, энергийн хяналтын журам	СҮАЖ-ЦПТЭХЖ-11	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2019 он ....сар ....өдөр
		Тушаал №	

## ЦООЖ, ПАЙЗ, ТУСГААРЛАЛТ, ЭНЕРГИЙН ХЯНАЛТЫН ЖУРАМ

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	Д.Батбаатар	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../ /...../	Э.Амарсайхан М.Баярцэнгэл	ХАБЭА-н бүртгэл хяналтын ажилтан	

Цоож, пайз, тусгаарлалт, энергийн хяналтын журам	СҮАЖ-ЦПТЭХЖ-11
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Цоож, пайз, тусгаарлалт, энергийн хяналтын журам	СҮАЖ-ЦПТЭХЖ-11
	Хувилбар: 1

## Агуулга

Нэг. Зорилго .....	4#
Хоёр: Хамрах хүрээ хүрээ .....	4#
Гурав. Нэр томъёоны тодорхойлолт .....	4#
Дөрөв. Үйл ажиллагаа .....	4#
Тав. Хариуцлага.....	7#

Цоож, пайз, тусгаарлалт, энергийн хяналтын журам	СҮАЖ-ЦПТЭХЖ-11
	Хувилбар: 1

### Нэг. Зорилго

1.1. Энэхүү журмын зорилго нь “Таван толгой түлш” ХХК-ийн /цаашид Компани гэх/ ажилтнууд бэртэж гэмтэх, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тоног төхөөрөмжид өмчийн хохирол үүсэхээс хамгаалж машин, тоног төхөөрөмжийг тусгаарлах, засварын ажилд бэлтгэх буюу засварын ажлын явцад тухайн тоног төхөөрөмж санамсаргүй болон бусад байдлаар залгагдах боломжгүй болгоход оршино.

### Хоёр: Хамрах хүрээ хүрээ

2.1. Компанийн цоож, пайз ашиглах эрх бүхий албан тушаалтнууд тоног төхөөрөмжийг тусгаарлах, засвар үйлчилгээ хийхэд ашиглана.

2.2. Компанийн нийт ажилтан, албан тушаалтан, гэрээт болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн ажилтнуудад хамаарна.

### Гурав. Нэр томъёоны тодорхойлолт

3.1. **Хувь хүний цоож** – Зөвхөн нэг хүний эзэмшил бүхий ганц хувь түлхүүр бүхий зүүдэг аливаа цоожыг хэлнэ. Цоожийг бүх төрлийн засварын болон технологийн ажлын үед цахилгаан тоног төхөөрөмжийн удирдлагын товчлуурыг санамсаргүй байдлаар залгахгүйн байх зорилгоор хэрэглэнэ.

3.2. **Хувь хүний таниулах пайз** – Пайз нь цоож эзэмшигчийг тодорхойлно. Хувь хүний цоож бүр дээр зүүдэг цаасан эсвэл хуванцар таних пайз байх бөгөөд түүн дээр **“Ажиллуулахыг хориглоно!”** гэсэн бичиг, эзэмшигчийн ажилладаг хэсэг, нэгж, овог нэрийг тодорхой бичсэн, бүртгэлийн дугаартай байна.

3.3. Пайз нь 2 өнгөтэй байна. Үүнд:

- Ажил удирдагч улаан өнгийн пайзтай.
- Ажил гүйцэтгэгч цэнхэр өнгийн пайзтай байна.

3.4. **Олон нүхтэй оньс** – Тухайн тоног төхөөрөмжүүдийг хүчдлээс тасалж, зогсоосны дараа түүн дээр засвар үйлчилгээ, үзлэгийн ажил гүйцэтгэх хэд хэдэн бригад, ажилчид зэрэг ажиллах тохиолдолд ажил хариуцагч нар нь хувийн цоожоо пайзны хамт унтраалга дээр тавьсан оньсонд цоожилно. Өөрөөр хэлбэл хамгийн сүүлчийн ажилчин ирж цоож, пайзаа автал тухайн тоног төхөөрөмж энергийн эх үүсвэрт холбогдох боломжгүй юм.

### Дөрөв. Үйл ажиллагаа

4.1. Цоож пайз бүр нь эзэмшигчийн нэр дээр бүртгэлтэй байна. Бүртгэлийг хэсгийн дарга хийнэ.

4.2. Цоож, пайз тавих, авах

4.2.1. Цоож пайз зүүх ажил удирдагчын эрхийг уг журманд заагдсан жагсаалтын дагуу дараах хүмүүс эдэлнэ. Үүнд:

- Цахилгааны инженер
- Цахилгаанчин

Цоож, пайз, тусгаарлалт, энергийн хяналтын журам	СҮАЖ-ЦПТЭХЖ-11
	Хувилбар: 1

- Засварын механик
- Засварчин
- Дулааны инженер
- Зуухны мастер
- Слесарь
- Ээлжийн ахлах
- Ашиглалтын инженер

4.2.2. Компанийн цоож, пайз ашиглах сургалтанд хамрагдсан эрх бүхий бүх ажилчин хувийн цоож, пайзтай байна. Хувийн цоож нь зөвхөн нэг хувь түлхүүртэй байна. Кодтой цоож ашиглахыг хориглоно.

4.2.3. Тоног төхөөрөмжийг цахилгаан хангамжаас тусгаарласаны дараа тухайн ажил удирдагч бүх боломжит байрлалаас тухайн тоног төхөөрөмжийг асаах оролдлогыг хийж тухайн тоног төхөөрөмж дээр тусгаарлалт зөв хийгдсэн эсэхийг шалгана.

4.2.4. Ажилтан нь хувийн цоож, пайзыг тухайн тоног төхөөрөмжийн удирдлагын хэсэг болон тоног төхөөрөмжийг гол цахилгаан хангамжаас тусгаарлах залгах салгах залгуур дээр цоож, пайзыг хамт зүүнэ.

4.2.5. Аливаа тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээнд нэгээс дээш бригад зэрэг орж ажиллах шаардлага гарвал олон нүхтэй оньсыг ашиглана. Ажил удирдагчид хувийн цоожоо пайзны хамт залгах, салгах залгуур дээр тавьсан оньсонд цоожилно. Ажил удирдагч нь хамгийн сүүлчийн ажилчин ирж цоож, пайзаа авсаны дараа тухайн тоног төхөөрөмжийг энергийн эх үүсвэрт холбох шийдвэрийг ажил гүйцэтгэгчид өгнө.

4.2.6. Хувийн цоож, пайз нь ажил дуустал эсвэл ажилтан ажлын талбайг орхих хүртэл болон завсарлага, үдийн хоолонд орох үед ч байрлуулсан газартаа байх ёстой.

4.2.7. Ажилтнуудын хэн ч байсан бусдын тавьсан хувийн цоож болон пайзыг авах, хөдөлгөхийг хориглоно. Мөн ямарч нөхцөлд хувийн цоож болон пайзаа авахгүйгээр ажлаас буухыг хориглоно.

4.2.8. Ажилтан хувийн цоож, пайзаа авалгүй явсан эсвэл мартсан бол цоожыг авах зөвшөөрлийг хэсгийн даргаас авна. Зөвшөөрөл авсаны дараа ажил удирдагч тухайн тоног төхөөрөмжийн дотор болон ойр орчмыг сайтар шалган ямарваа хүн, саад байхгүйг баталгаажуулан шалгасаны дараагаар цоож пайз авахад шаардлагатай “Хэвийн бус цоож салгалт” баримтыг бөглөж бүрдүүлсэн байх ёстой.

4.2.9. Хэрвээ ажилтны хувийн цоож эвдэрсэний улмаас салгаж чадахгүй тохиолдолд хэсгийн даргад мэдэгдэж “Хэвийн бус цоож салгалт” баримтыг бөглөн бүрдүүлсэний дараагаар ажил хариуцсан ажил удирдагч цоожыг салгаж авна.

4.3. Цоож пайзыг хадгалах

Цоож, пайз, тусгаарлалт, энергийн хяналтын журам	СҮАЖ-ЦПТЭХЖ-11
	Хувилбар: 1

4.3.1. Цоож пайзыг хадгалахдаа Ерөнхий инженерийн өрөөнд тусгай самбарт өлгөж хадгална.

4.3.2. Цоож пайз хадгалж буй өрөө нь байнга цоожтой байх бөгөөд гадны хүн орохыг хориглоно. Хэрвээ өрөөг цоожлох боломжгүй бол самбарт хаалт хийж цоожилно.

4.4. Цоож пайзны тавих дэс дараалал

4.4.1. Тоног төхөөрөмжид үзлэг, засвар үйлчилгээний ажил эхлэхийн өмнө хэсгийн дарга ажил удирдагчыг томилж ажлын наряд зааварчилгааг бичгээр өгнө.

4.4.2. Ажил удирдагч нь тоног төхөөрөмжийг засварт оруулахаар зогсоох талаар шууд удирдлагатайгаа зөвшилцсөний дараа тухайн тоног төхөөрөмжийг хариуцан ажиллаж буй ажилтанд зогсоох даалгавар өгч, зогсоолгоод энэ тухай ажил гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

4.4.3. Ажил гүйцэтгэгч өөрийн биеэр уг тоног төхөөрөмж зогссон эсэхийг шалгаж үзээд хүчдлийн таслалт хийж, таслаж – залгах аппаратын гар залгуур болон удирдлагын түлхүүр буюу товчлуурыг дээр “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна.” гэсэн хориглох тэмдгийг өлгөж, өөрийн цоож, пайзыг зүүнэ.

4.4.4. Ажил удирдагч нь тухайн тоног төхөөрөмжийн удирдлагын залгах түлхүүр буюу товчлуурыг дарж, уг тоног төхөөрөмж хүчдэлгүй болсон эсэхийг шалгаад өөрийн нэр бүхий цоож, пайзыг удирдлагын залгах салгах түлхүүр буюу товчлуурыг дээр нэмж зүүгээд, засварын бригад, ажилчдыг ажилд оруулна. Цоож пайз зүүсэн талаар “Цоож пайз тавих, авах” дэвтэрт бүртгэж гарын үсэг зурж баталгаажуулна.

4.4.5. Засвар, үйлчилгээний ажил дууссаны дараа ажил удирдагч нь аюултай бүсээс хүмүүсийг гаргаж, бригадын гишүүдийг бүртгэнэ. Бүртгэсний дараа тоног төхөөрөмжид үзлэг хийж, аюултай бүсэд хүн болон багаж, бусад зүйлс байгаа эсэхийг шалгасаны дараа өөрийн цоож, пайзыг авч “Цоож пайз тавих, авах” дэвтэрт хөтлөлт хийж гарын үсэг зурж баталгаажуулна. Дараа нь ажил гүйцэтгэгчид уг тоног төхөөрөмжийг хүчдэлд залгах зөвшөөрлийг өгнө.

4.4.6. Ажил гүйцэтгэгч ажил удирдагчыг цоож пайзаа авсаны дараа хувийн цоож пайзаа авч “Цоож пайз тавих, авах” дэвтэрт зохих хөтлөлт хийж “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна.” гэсэн хориглох тэмдгийг авч тоног төхөөрөмжийг хүчдэлд залгаж өгнө.

4.4.7. Нэг тоног төхөөрөмж дээр хоёр ба түүнээс олон засварын бригад орж ажиллах бол хэсгийн дарга тухайн ажлын удирдагчыг томилох ба ажлын удирдагч цоож пайз тавих авах дарааллын дагуу ажиллаж, бригадыг ажилд оруулна.

4.4.8. Хэрвээ тоног төхөөрөмж дээр хийгдэж байгаа засварын ажил сунжирч дараагийн ээлж (хоног)-т хийгдэхээр болбол ажил удирдагч дараагийн ээлжийн мастерт удирдлагыг хүлээлгэн өгч өөрийн цоож, пайзыг авч, дараагийн ээлж хүлээн авсан мастер өөрийн цоож пайзыг сольж зүүгээд “Цоож пайз тавих авах” дэвтэрт хөтлөлт хийж гарын үсэг зурж баталгаажуулна.



Цоож, пайз, тусгаарлалт, энергийн хяналтын журам	СҮАЖ-ЦПТЭХЖ-11
	Хувилбар: 1

4.4.9. Хэрвээ засварын бригадын бүрэлдэхүүнээс хүн дутуу байвал цоож пайзыг авах, тоног төхөөрөмжийг хүчдэлд залгаж, ажилд оруулахыг хатуу хориглоно.

#### **Тав. Хариуцлага**

5.1. Ажил удирдагч болон ажил гүйцэтгэгч нь “Цоож пайз тавих, авах” дэвтэр дээрхи бичилт үнэн, зөв байх үүргийг хүлээнэ. Бичиглэл хийхдээ засах үйлдэл хийхийг хориглоно. Шаардлагатай тохиолдолд бичиглэл буруу болохыг заан бичиж, өөрийн албан тушаал, овог нэр, он сар өдөр, цагийг бичээд гарын үсэг зурж баталгаажуулаад буруу бичсэн мөрний доод талын мөрөнд шинээр эхлэн бичнэ.

5.2. Хэсэг нэгжид ашиглагдаж байгаа цоож пайзны хадгалалт, ашиглалтын бүртгэлийг хэсгийн дарга хариуцна.

5.3. “Цоож пайз тавих авах” дэвтэрийн бүх хуудас дугаарлалттай байх бөгөөд сүүлчийн хуудсанд бичиглэл хийж дууссаны дараа уг дэвтрийг нэг сарын хугацаанд хадгална.

5.4. Цоож, пайзны системийг хэрэглэх журмыг зөрчсөн тохиолдолд ажлаас халах хүртэл захиргааны арга хэмжээ авч болно.

5.5. Хувийн цоож болон пайзыг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд уг ажилтныг 1 сарын хугацаагаар цалинг 20%-иар бууруулах арга хэмжээ авах бөгөөд шинээр цоож авах зардлыг цоож, пайз эзэмшигч хариуцана.

5.6. Цоож пайзны систем хэрэглэх тухай журмын шаардлагыг биелүүлэх, мөрдөлтөнд хяналт тавих үүргийг хэсгийн дарга, инженер хүлээнэ.